

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030, Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2016 оны орон нутгийн сонгуульд оролцсон Монгол Ардын Намын мөрийн хөтөлбөр, бусад нам, ИТХ-ын төлөөлөгчид, иргэний нийгмийн байгууллага, төрийн байгууллагууд, иргэд сонгогчдын саналд тулгуурлан 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрөө тодорхойлж байна.

Орон нутгийн уламжлалт технологиор хийж бүтээж байсан баялаг туршлага, үржил шимт үзэсгэлэнт газар нутаг, мал сүрэг, оюуны өндөр чадамжтай иргэдээ түшиглэсэн хөнгөн үйлдвэрийн цогц бодлогыг хэрэгжүүлж тогтмол орлого, байнгын ажлын байраар иргэдээ хангаж тогтвортой эдийн засаг, нийгэм, ногоон хөгжлийг цогцлоон төрөлх нутгаа хөгжүүлэх нь бидний эн тэргүүний зорилт байх болно.

НЭГ.ТОГТВОРТОЙ ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Бүс нутгийн хэрэглээг хангахад чиглэгдсэн үйлдвэрүүдийг дэмжиж, импортыг орлох, гадаад зах зээлд чиглэсэн жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, иргэдийнхээ тав тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэн эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг хэрэгжүүлнэ.

1.1."Хэрэглэгчээс-үйлдвэрлэгч" аймаг болох чиглэлээр:

1.1.1. "21:100" хөтөлбөрийн хүрээнд өргөн хэрэглээний 8 нэрийн бараа бүтээгдэхүүнийг аймагтаа үйлдвэрлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

1.1.2. Жимс жимсгэний бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, үхрийн нүд, чацарганы тариалалт, үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжинэ.

1.1.3. Органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлж, мал амьтан, ургамлын гаралтай түүхий эдийг анхан шатны болон эцсийн бүтээгдэхүүн болгон боловсруулах чиглэлээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийг дэмжиж, үйлдвэрлэлийн аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүн, сүү сүүн бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ.

1.1.4. Иргэдийн эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцөлийг бүрдүүлж, хүнсний бүтээгдэхүүний бэлтгэл, боловсруулалт, хадгалалт, тээвэрлэлт, борлуулалтын тогтолцоог бий болгож, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэхийг дэмжинэ.

1.1.5. Жижиг бизнес эрхлэгчид, өрх толгойлсон эмэгтэйчүүдийг дэмжиж “Өрх бүр үйлдвэрлэгч” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн сум, багийн нутгаар өнгөрч байгаа цахилгааны эх үүсвэрийг ашиглан жижиг үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

1.1.6. “Архангайд үйлдвэрлэв” төв байгуулж үйлдвэрлэгчдийг бүтээгдэхүүнээ сурталчлах, зах зээлд нийлүүлэх, үйлдвэрлэгч, бизнес эрхлэгч аж ахуй нэгж, иргэдийн бүтээгдэхүүнийг борлуулах сувгуудыг нээж өгөх бизнес уулзалт үзэсгэлэн худалдааг тогтмол зохион байгуулна.

1.1.7. Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилготой “Мах, сүүний анхдугаар аян”-д аж ахуй нэгж, иргэдийг дэмжин оролцуулна.

1.1.8. Туслах аж ахуй, эрчимжсэн мал аж ахуй хөгжүүлэх, загас үржүүлэх аж ахуй байгуулах санал, санаачилга гаргасан аж ахуйн нэгж, иргэдийг дэмжинэ.

1.1.9. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд туслах зөвлөгөө, мэдээлэл, сургалтын үйлчилгээ үзүүлэх бизнес инкубатор төвийг байгуулна.

1.1.10. Ноос угаах, ангилах үйлдвэр, сарлагийн хөөвөр боловсруулах үйлдвэр байгуулах санал, санаачилга гаргасан аж ахуйн нэгж, иргэдийг дэмжинэ.

1.1.11. Инновацид суурилсан үйлдвэрлэл, үйлчилгээг бодлогоор дэмжиж ажлын байр, ажиллах хүчин бүрдүүлэх, гадаад дотоодын зах зээлд нэвтрүүлэх боломж бүрдүүлж, үйлчилгээний нэр төрлөөр нь зохистой байршуулна.

1.1.12. Тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагаанд дотоодын давуу эрх тооцох замаар орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

1.1.13. Хүнсний үйлдвэрлэл, хүн амын хүнсний хэрэглээний нэгдсэн мэдээллийн сан, сүлжээг бий болгоно.

1.2.Хөдөө аж ахуйн чиглэлээр:

1.2.1. Нийт сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчимжсэн загвар, цогцолбор аж ахуйг олноор бий болгон импортыг орлох түүхий эд, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд бий болгоно.

1.2.2. “Монгол мал” үндэсний хөтөлбөр, Атрын III дугаар аяныг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

1.2.3. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого” –ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Монгол малчин”, “Малжуулах”, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөрүүдийг орон нутагт хэрэгжүүлнэ.

1.2.4. Малчдын бүлэг хоршоодыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтанд оруулж тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлж, мал аж ахуйн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

1.2.5. Малыг бүртгэлжүүлж, малын гаралтай түүхий эд бэлтгэлийн чанар стандартыг дээшлүүлж, гарал үүслийг тодорхой болгох системийг хэрэгжүүлнэ.

1.2.6. Мал эмчилгээний төвийг байгуулж, мал эмнэлгийн албаны тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж, үйл ажиллагааны шуурхай, нэгдмэл байдлыг ханган, мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг хяналтад авч эрүүл малтай аймаг болох арга хэмжээг хэрэгжүүлнэ.

1.2.7. Мал эмнэлгийн хяналтын цэгт тээврийн хэрэгсэл халдваргүйжүүлэх үйлчилгээ нэвтрүүлэн малын гоц халдварт өвчний голомт бүхий бүс нутгаас халдвар дамжин тархахаас сэргийлнэ.

1.2.8. Аймгийн Мал эмнэлгийн лабораторийг орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжөөр хангах, үндэсний тохирлын шаардлага хангасан лаборатори болгох ажлыг шат дараатайгаар зохион байгуулна.

1.2.9. Малын удмын сан генетик нөөцийг сайжруулах, үржил селекцийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулж, биотехнологийн ололтыг нэвтрүүлэн нийт сүрэгт цөм сүргийн малын эзлэх хувийг нэмэгдүүлэн, шинэ үүлдэр, омгийг бий болгохыг дэмжинэ.

1.2.10. Тохиромжтой бүс нутагт мал нядлах, мах боловсруулах үйлдвэр, хорио цээрийн бүс байгуулан худалдааны хорио цээрт өвчингүй эрүүл бүсээс экспортын махны нөөц бүрдүүлнэ.

1.2.11. Хөдөөгийн хүн ам, мал сүрэг, бэлчээрийн усан хангамжийг сайжруулах зорилгоор сумдад уст цэгийн тоог нэмэгдүүлнэ.

1.2.12. Бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, даац багтаамжийг тохируулахад чиглэсэн газар зохион байгуулалтын төлөвлөлт хийж, сум дундын отрын бүс нутаг, нөөц бэлчээртэй болох, хортон мэрэгчтэй тэмцэх оновчтой менежментийг нэвтрүүлнэ.

1.2.13. Хөдөө аж ахуйн салбарыг байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлэх, газар тариалангийн бүс нутгийг түшиглэн малын тэжээлийн үйлдвэрлэлийг хөгжүүлж аймгийнхаа хэрэгцээг хангана.

1.2.14. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлж малчид, тариаланчид, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд шаардлагатай тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлөөр олгохыг дэмжин сумдад техник үйлчилгээний төв байгуулна.

1.2.15. Газар тариалангийн услалтын системийн ашиглалтыг сайжруулж, усалгаатай газар тариаланг нэмэгдүүлэн, дуслын болон усалгааны орчин үеийн тоног төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэхийг дэмжинэ.

1.2.16. Эрдэнэбулган суманд төмс, хүнсний ногоо хадгалах орчин үеийн автомат зорь байгуулах, өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэхийг дэмжинэ.

1.3. Дэд бүтцийг хөгжүүлэх талаар:

1.3.1. Төвлөрсөн инженерийн байгууламж бүхий шугам сүлжээнд холбогдсон орон сууцыг нэмэгдүүлэх, иргэдийг орон сууцны зээлд хамруулан ая тухтай орчин нөхцөлд ажиллаж амьдрах боломжийг бүрдүүлнэ.

1.3.2. Аймаг, сумдын газар зохион байгуулалтын болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулна.

1.3.3. Эрдэнэмандал суманд хэрэгжиж эхэлсэн “Үйлдвэрлэл, технологийн парк” байгуулах ажлыг үргэлжлүүлнэ.

1.3.4. Шаардлагатай зарим сумын төвүүдийг нэгдсэн халаалтын системд $\bar{o}\bar{i}\bar{e}\bar{a}\bar{i}\bar{o}\bar{a}\bar{i}\bar{e}\bar{i}\bar{i}\bar{a}\bar{x}\bar{i}\bar{o}\bar{o}\bar{o}\bar{e}\bar{e}\bar{e}\bar{e}\bar{a}\bar{n}\bar{o}\bar{a}\bar{e}\bar{a}\bar{i}\bar{o}\bar{o}\bar{o}\bar{a}\bar{e}\bar{e}\bar{i}\bar{o}\bar{y}\bar{a}\bar{o}\bar{e}\bar{e}\bar{e}\bar{i}\bar{o}\bar{a}\bar{i}\bar{o}\bar{u}\bar{i}\bar{o}\bar{o}\bar{o}\bar{i}\bar{x}\bar{i}\bar{o}\bar{o}\bar{e}\bar{e}\bar{e}\bar{o}\bar{a}\bar{a}\bar{r}$ шийдвэрлэнэ.

1.3.5. Гэр хорооллын дахин төлөвлөлтийг эхлүүлэн айл өрхүүдийг цэвэр, бохир усны нэгдсэн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлж, орчин үеийн тохилог TOWN-HOUSE-уудыг бий болгох төслийг дэмжинэ.

1.3.6. Наран, Доной чиглэлийн хэсэгчилсэн $\bar{a}\bar{o}\bar{i}\bar{o}\bar{e}\bar{e}\bar{o}\bar{o}\bar{e}\bar{e}\bar{a}\bar{e}\bar{o}\bar{x}\bar{o}\bar{a}\bar{b}\bar{o}\bar{v}\bar{s}\bar{r}\bar{u}\bar{u}\bar{l}\bar{a}\bar{n}$, дэд бүтэц, нийтийн тээврийн үйлчилгээг бий болгох төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжинэ.

1.3.7. Цэцэрлэг хотын өрх бүрт хямд интернэт, олон нийтийн үйлчилгээний байгууллагуудад ашиглах утасгүй wi-fi интернэтийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

1.3.8. Бүх сумыг интернэтийн сүлжээнд бүрэн хамруулж, сумын төвүүдэд орон нутгийн телевизийн нэвтрүүлгийг хүлээн авах боломж бүрдүүлнэ.

1.3.9. Шаардлагатай зарим багийн төвүүдийг үүрэн холбооны сүлжээ болон өндөр хүчдэлийн шугаманд холбоно.

1.3.10. Цэцэрлэг хотод 10/0.4 кв-ын дэд өртөө байгуулж, 0.4 кв-ийг өрөөлөн шинэчлэн айл өрхөд ухаалаг тоолуур нэвтрүүлнэ. Шаардлагатай сумдад дэд станц нэмж суурилуулах, шугам шинэчлэх ажлыг зохион байгуулна.

1.3.11. Түгээмэл тархацтай байгалийн баялагийг ашиглан барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлэх, барилгын бетон хийц, эрдэс будаг зэрэг барилгын материалын үйлдвэрлэлийг дэмжинэ.

1.3.12. Аймгийн Барилгын материалын сорил шинжилгээний лабораторийг тоног төхөөрөмжөөр бүрэн хангаж, үйл ажиллагааг нь тогтмолжуулан итгэмжлэгдсэн лаборатори болгоно.

1.3.13. Цэцэрлэг хотын цэвэр усны эх үүсвэрийн харуул, хамгаалалтыг сайжруулж, хяналтын систем нэвтрүүлэн, ундны усны шинэ эх үүсвэр /2 дахь эх /-тэй болгож, цэвэр усны худгуудыг нэгдсэн системд холбох ажлыг эхлүүлэн усыг зүй зохистой ашиглах, ард иргэдийг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн усаар хангах бодлогыг баримтлана.

1.3.14. Дулааны станц байгуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлж Цэцэрлэг хотын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажиллана.

1.3.15. Ус, дулаан, цахилгааны үнийг тогтвортой байлгаж, цаашид үе шаттайгаар бууруулах бодлого баримтална.

1.3.16. Цэцэрлэг хотод дэвшилтэт технологи бүхий цэвэрлэх байгууламж барина.

1.3.17. Эрдэнэбулган сумын “Булганхангай” хорооллын бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэн өрнүүлнэ.

1.3.18. Аймгийн төв болон сумдад “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалттайгаар хэрэгжүүлэхийг дэмжинэ.

1.3.19. Аймаг, сумдын төвийн гудамжны гэрэлтүүлгүүдийг зарцуулалт багатай, сэргээгдэх эрчим хүч ашиглан шийдвэрлэнэ.

1.3.20. Аймгийн төвийн хуучин барилга, хорооллын дахин төлөвлөлтийг эхлүүлнэ.

1.3.21. Цэцэрлэгт хүрээлэн, гудамж талбай, орон сууцнуудын гадна фасад, зам, талбайг тохижуулж хотын өнгө үзэмжийг сайжруулна.

1.3.22. Төрийн албан хаагч, ажилчдын орон сууцыг төрийн болон хувийн барьж байгуулах төслийг дэмжинэ.

1.3.23. Төрийн суурь үйлчилгээний барилга байгууламжуудыг шинээр барьж байгуулах, өргөтгөл, их засварын ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ. /Сургууль, Цэцэрлэг, Эмнэлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төв, ЗДТГ, Багийн төв, төрийн бусад байгууллагууд г.м/

1.3.24. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол Ихтамир чиглэлийн гүүр, замыг гүйцээж мянганы замд холбох, Өгийнуур-Өлзийт-Хайрхан-Хөвсгөлийн чиглэлийн хатуу хучилттай авто замын сүлжээг барьж байгуулах ажлыг эрчимжүүлнэ.

1.3.25. Улсын болон орон нутгийн чанартай замд хаягийн тэмдэглэгээг стандартын дагуу шинээр хийж байршуулна.

1.3.26. Аймгийн төвийн гудамж зам талбайг шинэчлэх, үерийн далан байгуулах, иргэдийн зорчих хэсэг дээр гүүр барих, хатуу хучилттай замуудыг ус зайлуулах сувагтай болгох, хатуу хучилттай болон сайжруулсан замыг нэмэгдүүлж иргэдийн ая тухтай амьдрах орчин бүрдүүлнэ.

1.3.27. Эдийн засгийн үр ашиг бүхий стратегийн ач холбогдолтой зам, даваа, гүүр засварлах, шинээр барих ажлуудыг үе шаттай хэрэгжүүлнэ.

1.3.28. Газар олголтыг цахим системд шилжүүлж, газрын биржийн үйл ажиллагааг нэвтрүүлнэ.

1.4.Санхүү төсөв, өмчийн харилцаа, худалдан авах ажиллагааны чиглэлээр:

1.4.1. Аймгийн орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлтийг жигд ханган биелүүлэх, татвар хураалт, хяналтад мэдээллийн технологийг түлхүү ашиглаж, татварын бааз суурийг тэлэн татвар төлөгч бүрт хүрсэн татварын цогц үйлчилгээг хэрэгжүүлнэ.

1.4.2. Орон нутгийн төсвийн тэнцвэрт байдлыг хангаж, төсвийн зарцуулалтыг хөтөлбөрт суурилсан арга хэмжээний бодит үр дүнд тулгуурлан санхүүжүүлэх бодлого баримтална.

1.4.3. Төсвийн сахилга, хариуцлагыг сайжруулж, төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албаны үйл ажиллагааг бэхжүүлнэ.

1.4.4. Төрийн сангийн төлбөр тооцооны үйлчилгээний чирэгдэлгүй, хөнгөн шуурхай, соёлтой харилцааг сайжруулна.

1.4.5. Орон нутгийн өмчийн ашиглалт, хяналтыг сайжруулж үр ашгийг нэмэгдүүлнэ.

1.4.6. Орон нутагт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөр арга хэмжээний тендер шалгаруулалтыг олон нийтэд ил тод болгож “Шилэн тендер шалгаруулалт”-ын бодлогыг хэрэгжүүлнэ.

ХОЁР.ТОГТВОРТОЙ НИЙГМИЙН ХӨГЖИЛ

Гэр бүлийг дэмжин тэтгэх, иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөл бүрдүүлэхэд бүх талаар анхаарч ажилгүйдэл, ядуурлыг бууруулан дундаж орлоготой өрхийн тоог нэмэгдүүлж, иргэдийнхээ амьжиргааг сайжруулна.

2.1.Эрүүл мэндийн салбарын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1.1. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн тогтолцоог бэхжүүлэн Нэгдсэн эмнэлэг, Тариат, Эрдэнэмандал сумдын сум дундын эмнэлгүүдийг тусгай зориулалтын автомашинаар ханган сумдын эрүүл мэндийн төвүүдэд түргэн тусламжийн авто машины парк шинэчлэлийг тасралтгүй хийж шуурхай байдлыг хангаж ажиллана.

2.1.2. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хангалтыг эрүүл мэндийн байгууллагын бүтэц, үйл ажиллагааны стандартад нийцүүлэн 95 хувьд хүргэж, шинэ залуу эмч нарыг мэргэшүүлэх, өндөр технологитой тоног төхөөрөмж дээр дадлагажуулах арга хэмжээг үе шаттай зохион байгуулж “Архангай аймгийн эрүүл мэндийн салбарын ажиллагсдын хөгжил, нийгмийн хамгааллыг сайжруулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.3. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн оношилгоо, эмчилгээний чадавхийг сайжруулж, төрөлжсөн мэргэжлийн тусламжийг хөгжүүлэн, компьютер томографи, вирус тоолох оношлогоо, гемодиализийн болон дурангийн мэс заслын шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган эмчилгээний технологийг нэвтрүүлж, хөдөөгийн иргэдийн 3 дахь шатлалын эмнэлэгт шилжүүлэх урсгалыг нэг дахин багасгаж чирэгдэл, хүндрэлийг бууруулна.

2.1.4. Нэгдсэн эмнэлгийн сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээний тасгийн тоног, төхөөрөмжийн хангалтыг хийж, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэн эмнэлгийн хоног болоогүй нас баралтыг бууруулна.

2.1.5. Аймгийн нэгдсэн эмнэлгийг сумдын эмнэлгүүдтэй телеэмнэлгийн нэгдсэн сүлжээнд холбож, алсын зайнаас цаг алдалгүй онош тодруулах, зөвлөгөө өгөх, орон нутагт хийгдэхгүй байгаа шинжилгээний сорьц тээвэрлэх сүлжээг бүрдүүлэн ажиллаж эмнэлгийн тусламжийн чирэгдэлгүй, шуурхай ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.

2.1.6. Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эхийн эндэгдэлгүй ажиллан, хүүхдийн эндэгдлийг улс аймгийн дунджид хүргэж тогтвортой бууруулна.

2.1.7. Хүн амыг аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох халдварт бус өвчнийг эрт илрүүлэх зорилгоор Архангай аймгийн иргэн бүрийг нас хүйсэнд нь тохирсон эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэгт жил тутам хамруулж, алслагдсан орон нутагт явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг загвар байдлаар үзүүлнэ.

2.1.8. Хүн амын дунд өвчлөлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чанар, хүртээмжийг сайжруулан, “Элэгний эмгэггүй Архангай” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, 40-65 насны иргэдийн элэгний вирусийн халдварыг үнэ төлбөргүй оношилж, эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

2.1.9. Нөхөн сэргээх, фитнес спортын төвүүдийг байгуулахыг дэмжиж, идэвхитэй дасгал хөдөлгөөн, эрүүл зан үйл, эрүүл амьдрах хэв маягийг дэлгэрүүлэн, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.

2.1.10. Төр, хувийн хэвшлийн түншлэлийг эмнэлгийн тусламж үйлчилгээний тэргүүлэх чиглэл, бодит хэрэгцээтэй уялдуулах, улсын эмнэлгийн ачааллыг хуваалцахад хувийн хэвшлийн эмнэлгүүдийн оролцоог нэмэгдүүлэн хамтарч ажиллана.

2.1.11. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт “Эрэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх кабинет” ажиллуулна.

2.1.12. Эрүүл мэндийн салбарт гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, анагаах ухааны шинэ технологи, судалгаа, хүний нөөцийн сургалт, хөгжил, тоног төхөөрөмжийн шинэчлэлд хамтран сайн түншлэлийг бий болгож хөдөөгийн эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2. Боловсролын чиглэлээр:

2.2.1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын чанарыг сайжруулж, сургалтын түвшинг жил бүр тогтоон, шавь нарынх нь сурлагын ахицаар сургууль, багшийн ажлыг дүгнэдэг болгоно.

2.2.2. Монгол иргэнийг төлөвшүүлэх зорилгоор сургалтын явцад орон нутгийн байгаль, түүх, ёс заншил, соёл, хүмүүсийн амьдралыг сурталчилах, гарын авлага, ном зөвлөмж, тоног төхөөрөмж хэрэглэгдэхүүнээр хангах жижиг үйлдвэр, уламжлалт монгол тоглоомын цех байгуулахыг дэмжинэ.

2.2.3. Сургуулийн өмнөх боловсролын төрөл хэлбэрийг өргөтгөж, хүртээмж чанарыг сайжруулан, 2-5 насны хүүхдийн 85% -ийг сургуулийн өмнөх боловсролд хамруулна.

2.2.4. Хуучин Хөгжимт драмын театрын барилгыг “Хүүхдийн ордон” болгон хүүхэд бүрт хүртээмжтэй төрөл бүрийн дугуйлан секц ажиллуулан хүүхдийн авьяасыг нээн хөгжүүлнэ.

2.2.5. “Архангайн хүүхэд–Архангайн баялаг” хэмээн үзэж боловсролын салбарт оруулах хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлж хүүхэд багачуудын сурах орчныг сайжруулан сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг боловсролын стандартад нийцүүлэн шинэчилж хүүхэд бүрт хүртээмжтэй чанартай боловсрол олгоно.

2.2.6. Хүүхэд бүрийг урлаг спортын аль нэгэн төрлөөр хичээллэх боломж бүрдүүлж, “Ирээдүй 1+1” хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.2.7. Бүх нийтийн Монгол хэл, бичгийн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, суралцагчдын эх хэлээрээ алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх, хэрэглээний бүрэн ур чадвартай болгон, үндэснийхээ хэл бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлнэ.

2.2.8. Эмзэг бүлгийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн суралцах орчин нөхцөлийг сайжруулж, боловсролын үйлчилгээний хүртээмж чанар үр ашгийг нэмэгдүүлэн, сургууль завсардсан хүүхдэд боловсрол нөхөн олгоно.

2.2.9. “Сувилалын цэцэрлэг” байгуулж үйл ажиллагааг нь өргөжүүлнэ.

2.2.10. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байр, хүүхдийн цэцэрлэгийн хатуу зөөлөн эдлэлийг шинэчилж, тоглоом наадгайгаар хангана.

2.2.11. Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн гал тогоог цахилгаан тоног төхөөрөмжөөр хангаж, “Үдийн цай” хөтөлбөрийг чанаржуулна.

2.2.12. Цахим сургалтын орчин, өндөр хурдны интернет ашиглах боломж бүрдүүлж, боловсролын удирдлага мэдээллийн нэгдсэн системийг бүрэн нэвтрүүлнэ.

2.2.13. Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш нарын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, чадавхижуулах, тэдний сурч, ажиллах орчинг сайжруулах, нийгмийн баталгааг хангахад чиглэсэн “Багшийн хөгжил” дэд хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

2.2.14. Насан туршийн боловсролын үйлчилгээний төрөл, хэлбэрийг өргөжүүлж, багш нарыг чадавхижуулан, насан туршийн боловсролын төвүүдийн материаллаг баазыг бэхжүүлж, иргэдэд хүргэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.2.15. Боловсролын салбарт хувийн хэвшил, гадаадын төсөл, хөтөлбөрийн хөрөнгө оруулалтыг дэмжиж, боловсролын салбарын материаллаг баазыг бэхжүүлж хамтран ажиллана.

2.2.16. Эко сургуулиудыг бий болгож, сургууль цэцэрлэгийг халаалт, дулаан, ундны усны бие даасан эх үүсвэртэй болгож, ариун цэврийн байгууламжийг сайжруулна.

2.2.17. Багш, ажилтныг ажлын байрандаа хөгжих орчин нөхцлийг бүрдүүлж “Багш хөгжлийн танхим”-ыг техник, тоног төхөөрөмжөөр хангана.

2.3. Соёл, урлагийн чиглэлээр:

2.3.1. Аймгийн байгаль түүх соёлыг илэрхийлсэн соёл урлагийн бүтээл, дуу, шүлэг, кино, ном зохиолуудыг бүтээх олон нийтэд түгээн дэлгэрүүлэх санал санаачилгыг дэмжиж ажиллана.

2.3.2. Архангайн соёлын өдрүүдийг бусад аймаг, хот, гадаад улс орнуудад зохион байгуулж аймгаа сурталчилна.

2.3.3. Соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, хадгалах, сэргээн засварлах, бүртгэн баримтжуулах, түгээн дэлгэрүүлэх, ардын авъяастнууд, урчууд, уран бүтээлчдийн бүтээлийг шинээр нээн илрүүлж сурталчилна.

2.3.4. Музейн ажлын байр, зориулалтын фондын барилгыг шинээр барьж, музейн танхимуудад шинэчилсэн үзмэр дэглэлт хийх, хорго савыг шинэчлэн, материаллаг баазыг бэхжүүлж, Монголын соёлын өв, уламжлалт ёс заншлыг аймгийн музейн үзмэр, түүх соёлын дурсгалуудаар дамжуулан иргэд, хүүхэд залуучуудад түгээн дэлгэрүүлнэ.

2.3.5. Аймгийн Хөгжимт драмын театрын барилгыг ашиглалтад оруулж, театрын үйл ажиллагааны менежментийг сайжруулан, шаардлагатай тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл, мэргэжлийн боловсон хүчнээр хангана.

2.3.6. Номын сангийн барилгыг ашиглалтанд оруулж, иж бүрэн тавилга, техник, тоног төхөөрөмжөөр ханган, хүн амд мэдээлэл, соёлын үйлчилгээг хүргэх төв болгон, “Цахим номын сан” төсөл хэрэгжүүлнэ.

2.3.7. Хөдөөгийн иргэдэд үзүүлэх соёл, урлагийн явуулын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.

2.3.8. Соёлын төвүүдийг мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, тэдний мэргэжил, боловсролыг дээшлүүлж, техник, тоног төхөөрөмжийг шат дараатай шинэчилнэ.

2.4. Спортын чиглэлээр:

2.4.1. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хүн бүр биеийн тамир, спортоор хичээллэх, байгууллага, хамт олон, өрх гэр бүлд эрүүл амьдралын орчин нөхцөлийг бүрдүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.4.2. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг өсвөр үе, насанд хүрэгчдийн ангиллаар зохион байгуулж, улс, бүс, тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээн, олимп, паралимпийн тэмцээнд баг, тамирчдыг бэлтгэж оролцуулна.

2.4.3. Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллага, спортын холбоод, аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

2.4.4. Үндэсний спортын өв соёлыг хөгжүүлж, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэн, “Мөсөн шагай” спортыг хөгжүүлэхийг дэмжиж ажиллана.

2.4.5. Хүүхэд залуучуудын чийрэгжилтийн төв Усан бассейны барилгыг ашиглалтанд оруулж, усан спортоор дамжуулан иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлнэ.

2.4.6. Үндэсний бөхийн залгамж халааг бэлтгэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлнэ.

2.5. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх чиглэлээр:

2.5.1. Бүтээмжтэй, тогтвортой ажлын байр бий болгоход төр, хувийн хэвшлийн оролцоог хангах замаар хөдөлмөр эрхлэлтийн өсөлтийг бий болгож, ажилгүйдлийн түвшинг 5.0 хувьд хүртэл бууруулж, хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлнэ.

2.5.2. Мэргэжлийн боловсролын салбарын удирдах ажилтан, багш сурган хүмүүжүүлэгчдийг чадваржуулах, мэргэжил дээшлүүлэх сургалтанд тогтмол хамруулна.

2.5.3. Зорилтот бүлгийн иргэдийг мэргэжлийн сургалтанд хамруулж өрхийн үйлдвэрлэл, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэх, хөдөлмөрөө хоршин ажиллах боломжоор хангана.

2.5.4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан ажил олгогчид санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

2.5.5. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх, суралцах, хөнгөлөлттэй зээлд хамрагдах, ажлын багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авахад нь дэмжлэг үзүүлнэ.

2.5.6. Мал зүйч, малын бага эмч мэргэжилтний 2-2.5 жилийн сургалттай ангийг МСҮТ-үүдэд нээж, хөдөө аж ахуйн боловсон хүчнийг бэлтгэнэ.

2.5.7. Ажлын байраа нэмэгдүүлсэн, хадгалсан аж ахуйн нэгжүүд, энэ чиглэлээр санаачилгатай ажилласан иргэд, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжих, борлуулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.5.8. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн судалгаанд үндэслэн ажил олгогч, ажил идэвхитэй хайгчид, ажилгүй иргэн, мэргэжлийн сургалтын байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах замаар 5000 ажлын байрыг шинээр бий болгоно.

2.5.9. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүдэд хамрагдаж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, ажил олгогч, сургалтын байгууллагад мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлэх замаар иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлнэ.

2.5.10. Бизнес эрхлэгч, жижиг дунд үйлдвэрлэгчдийг бусад оронд зохион байгуулагддаг томоохон бизнес уулзалт, үзэсгэлэн худалдаанд оролцуулж, шинэ технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлж ажиллахад нь бүх талаар дэмжинэ.

2.5.11. “Зээлийн батлан даалтын сан”-гаар дамжуулан сум багийн иргэдийн өрхийн бичил бизнес, жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг бүх талаар дэмжинэ.

2.6. Нийгмийн хамгааллын чиглэлээр:

2.6.1. Малчид, ажилгүй иргэд, албан бус хөдөлмөр эрхлэгчдийн нийгмийн даатгалд хамрагдалтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.

2.6.2. Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээг худалдан авах, тусламж үйлчилгээний чанарт тавих хяналтыг сайжруулж, эрүүл мэндийн даатгалын үр өгөөжийг нэмэгдүүлнэ.

2.6.3. Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг бүрдүүлж, даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмжийг шуурхай олгоно.

2.6.4. Сумдад “Ахмадын төв” байгуулахыг дэмжинэ.

2.6.5. Ахмад настны асаргаа үйлчилгээг сайжруулж, ахмадын зориулалттай амралт, рашаан сувилалд хөнгөлөлттэй үнээр амрааж тэдэнд чиглэсэн хууль эрх зүй, дасгал хөдөлгөөн, эрүүл мэндийн үйлчилгээг нэмэгдүүлнэ.

2.6.6. “Ахмадын зөвлөх үйлчилгээ”-г бий болгож, хүүхэд, залууст ажлын дадлага туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна.

2.6.7. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэдийн хөгжлийн төв”-ийг байгуулан иргэдийг чадавхижуулах, мэргэшүүлэх, сувилах зэрэг цогц үйлчилгээг хүргэнэ.

2.6.8. Төр, хувийн хэвшлийн үйлчилгээний байгууллагуудад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх дэд бүтцийг сайжруулна.

2.6.9. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг оновчтой тодорхойлж, тэдгээр өрхийн гишүүдийн эрэлт, хэрэгцээ, санаачлага, боломжинд тулгуурлан боловсрол, эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгаалал, санхүү, хөдөлмөр эрхлэлт зэрэг үйлчилгээг багцлан хүргэж амьжиргааны түвшинг нь дээшлүүлнэ.

2.7. Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн чиглэлээр:

2.7.1. “Гэрлэх ёслолын ордон” байгуулах санал санаачлагыг дэмжинэ.

2.7.2. Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэн, усан оргилуурыг сэргээн засварлаж байнгын үйл ажиллагаатай болгоно.

2.7.3. Гэр бүл, хүүхэд, залуучуудын дэд хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.7.4. Тамир кино театрыг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангаж, хүүхдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх газар болгон өргөжүүлнэ.

2.7.5. Хүүхэд бүрт ээлтэй, аюулгүй орчин бүрдүүлж, тэднийг болзошгүй эрсдэл, дарамт хүчирхийллээс хамгаалах, нөхөн сэргээх, нийгэмшүүлэхэд эцэг, эх, асран хамгаалагч, байгууллага хамт олон, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.

2.7.6. Хүүхдийн “Тамир” зусланг Хангайн бүсийн загвар зуслан болгож, хүүхэд амрах, хөгжих, хүмүүжих таатай нөхцөлийг бүрдүүлэн, амрагчийн тоог нэмэгдүүлнэ.

ГУРАВ.ТОГТВОРТОЙ НОГООН ХӨГЖИЛ

Ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн байгаль орчны унаган төрх, эко системийн тэнцвэрт байдлыг хадгалж, баялагийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, аялал жуулчлалын салбарыг хөгжлийн нэг тулгуур болгон хөгжүүлнэ.

3.1. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

3.1.1. “ХОРГО – ТЭРХ” олон улсын аялал жуулчлалын төв байгуулах ажлыг бодлогоор дэмжинэ.

3.1.2. Уламжлалт халуун, хүйтэн рашааныг түшиглэн эмчилгээ үйлчилгээ, аялал жуулчлалын цар хүрээг өргөжүүлнэ.

3.1.3. Орон нутгийн онцлог, давуу тал, иргэдийн ёс заншил ахуй амьдралд түшиглэсэн Булган уулын-Буман зул”, “Тамирын голын мөсөн шагай”, “Сарлагийн фестивал”, “Алтан зуу бурханы их мөргөл”, “Өгий нуур-Спорт загасчлал” зэрэг аялал жуулчлалын байнгын үйлчилгээ бий болгоход дэмжлэг үзүүлнэ.

3.1.4. “Аялал жуулчлал мэдээллийн төв”-ийн үйл ажиллагааг тогтмолжуулж мэдээллийн санг шинэчлэн олон улсын аялал жуулчлалын нэгдсэн сүлжээнд холбоно.

3.1.5. Цахир суманд “УВДИСТ ОРОН” шүтээн цогцолбор байгуулж аялал жуулчлалын бүс болгон хөгжүүлнэ.

3.1.6. Аялал жуулчлал эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг Архангай аймгийн харьяалалтай болгох, орлогыг орон нутагт төвлөрүүлэх, байгаль хамгаалах санг нийцдэг бий болгох, татварын бааз суурийг нэмэгдүүлэх ажлыг эхлүүлэн экосистемийн тэнцвэрт байдлыг хангах ажлыг эхлүүлнэ.

3.1.7. Аялал жуулчлалын нэгдсэн маршрут гаргаж дотоод, гадаадын аялагчдыг хямд зардлаар аялах боломж бүрдүүлнэ.

3.1.8. Олон улсын жишигт нийцсэн стандартын шаардлага хангасан зочид буудал, жуулчны баазуудыг олон улсын сүлжээнд холбоно.

3.1.9. Өгий нутгийн түүх соёлын дурсгалт газруудад түшиглэсэн “Соёлын аялал жуулчлал”-ыг хөгжүүлэхийг дэмжинэ.

3.1.10. Нутаг бэлчээрийг эзэмших, ашиглах, ой мод, самар, жимс, байгалийн дагалдах бүтээгдэхүүнийг хамгаалах, ашиглах асуудлыг шийдвэрлэхэд нутгийн иргэд, ойн нөхөрлөл, малчдын бүлэг, хоршоо зэрэг олон нийтийн санал санаачилгыг нэмэгдүүлнэ.

3.1.11. Өгий нуурын усны санг тэтгэх, урсацыг нэмэгдүүлэх, ногоон төгөл бий болгохыг бодлогоор дэмжинэ.

3.1.12. “Миний нутаг-миний бахархал” аян өрнүүлж өсвөр үеийг төрөлх аймаг, сумаараа бахархах сэтгэлгээг төлөвшүүлнэ.

3.1.13. Бэлчээрийн болон ойн хортонтой тэмцэх ажлыг зохион байгуулж байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгална.

3.1.14. Цөлжилттэй бүсэд мод, бут тариалах, ойг байгалийн жамаар нөхөж төлжих, сэргэн ургалтанд туслах, ойн зурвас байгуулах аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжин урамшуулна.

4.1.4. Төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг хэрэгжүүлж, амьдрах нөхцөлийг сайжруулах бодлого баримтална.

4.1.5. Төрөөс олгодог шагналын нэр хүндийг өсгөн, шалгуур үзүүлэлтийн дагуу шагнал олгох зарчим баримтлана.

4.1.6. Төрийн албан хаагчдыг бэлтгэх, сургаж хөгжүүлэх, мэргэшүүлэх танхимын болон зайн сургалтын хамрах хүрээг нэмэгдүүлж, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг байх нөхцөлийг дэмжинэ.

4.1.7. Төрийн бүх шатны байгууллагын хүний нөөцийн сонгон шалгаруулалтыг нээлттэй ил тод болгоно.

4.1.8. Төрийн үйлчилгээг иргэдэд хүргэдэг төрийн захиргааны анхан шатны нэгж багийн төвүүдийг бэхжүүлэх “Багийн хөгжлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

4.1.9. Төрийн байгууллагад ажиллаж буй мэргэжлийн боловсон хүчнийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад шаардагдах дэмжлэг туслалцааг үзүүлнэ.

4.1.10. Мэргэжлийн хяналтын газрын лабораторийг техник тоног төхөөрөмжөөр хангаж үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлнэ.

4.1.11. Нэг цонхны үйлчилгээний хэрэгжилтийг эрчимжүүлэн, явуулын нэг цэгийн үйлчилгээг өргөжүүлж, төрийн үйлчилгээг малчдад хөнгөн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулна.

4.1.12. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын үр нөлөөг дээшлүүлнэ.

4.1.13. Аймгийн хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг тооцон, санхүүжүүлэх эх үүсвэртэй уялдуулан хэрэгжүүлнэ.

4.1.14. Зөвлөлдөх ардчилал иргэдийн оролцоог дэмжих “Ардын засаглал” хөтөлбөрийн хүрээнд шийдвэр гаргахад иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ. “Иргэний танхим”-ын үйл ажиллагааг өөрчлөн сайжруулна.

4.1.15. Төрийн зарим чиг үүргийг иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлж хамтран ажиллана.

4.1.16. Үндэсний чанарын хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Аймгийн чанарын дэд хөтөлбөр” боловсруулан хэрэгжүүлнэ.

4.1.17. Жендэрийн тэгш байдлыг хангаж, шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.

4.2. Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх чиглэлээр:

4.2.1. Цагдаагийн мэдээллийн технологийн орчныг шинэчлэх ажлын хүрээнд хэсгийн төлөөлөгч нарыг унаажуулах, цагдаагийн байгууллагын автомашин харилцаа холбоо, нотлох баримт бэхжүүлэхэд шаардлагатай орчин үеийн техник хэрэгслэлээр хангахад хөрөнгө санхүүгийн туслалцаа үзүүлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.

4.2.2. Аймаг, сумын төвийн гэр хороолол, гудамж талбайг камержуулна.

4.2.3. Цагдаагийн газрын бүтэц орон тоог нэмэгдүүлэх ажлыг холбогдох газруудад уламжлан шийдвэрлүүлнэ.

4.2.4. Архи согтууруулах ундааны борлуулалтанд тавих хяналтыг сайжруулах, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчилдэг цэг салбарын тоонд зохицуулалт хийнэ.

4.2.5. Шүүхийн шинжилгээний албаны ажлын нөхцөл, лабораторийн техник тоног төхөөрөмжийг сайжруулах ажлыг холбогдох газарт санал тавьж шийдвэрлүүлнэ.

4.2.6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, иргэдэд хууль тайлбарлан таниулах, сургалт сурталчилгааны арга хэмжээг үе шаттай зохион байгуулна.

4.2.7. Цагдаагийн газарт Малын хулгайтай тэмцэх тасаг байгуулж, малчдын бүлэг, нөхөрлөлийг бүх суманд ажиллуулж, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, тухайн гэмт хэргийг бууруулах бодлого баримтална.

4.2.8. Байгаль орчны эсрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдал болон мэдээллийн аюулгүй байдлын гэмт хэргийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.

4.2.9. Хэрэглэгчийн эрхийг хамгаалж, тус чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллагуудыг дэмжиж ажиллана.

4.2.10. Аймгийн төв болон сумдад олон нийтийн цагдаа ажиллуулж хэвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

4.2.11. Тарнын гүүрний “Зам тээврийн хяналтын төв”-ийг аймгийн мэдэлд шилжүүлж үйл ажиллагааг тогтмолжуулна.

4.2.12. Цагаан давааны замд тээврийн хэрэгслийн ослын үед тээврийн хэрэгслийг зогсоох ослын зогсолтын зурвас байгуулах, зам тээврийн осол ихээр гардаг замуудын тэмдэг тэмдэглэгээг сайжруулна.

4.2.13. Осол гэмтэл, хүчирхийлэл, мал хамгаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

4.2.14. Торгууль шийтгэврийн орлогоос тодорхой хувийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулна.

4.2.15. Иргэн, хуулийн этгээд оюуны болон хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгийг өмчлөх эрхийн баталгааг сайжруулна.

4.2.16. Улсын бүртгэлийн хэлтсийн архивыг цахимжуулж, газар зүйн мэдээллийн системд суурилсан хаягжуулалтын нэгдсэн санг бий болгоно.

4.2.17. Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангаж, захиргааны байгууллагаас иргэдийн эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг багасгана.

4.2.18. Төрийн архивын баримт бичгийн 30 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, төрийн албан хэрэг хөтлөлтөд тоон гарын үсэг нэвтрүүлэх, мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх замаар төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулна.

4.2.19. Цахим архив бүрдүүлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, техник тоног төхөөрөмжөөр хангаж ажиллана.

4.2.20. Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд иргэдийн хяналтын зөвлөлийг байгуулан ажиллуулан, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажилд зарцуулагдах зардлыг жил бүрийн төсөвт суулгана.

4.2.21. Онцгой байдлын хэрэгцээнд шаардагдах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, материаллаг баазыг бэхжүүлнэ.

4.2.22. Монгол Улсын Засгийн Газрын 2015 оны 303 дугаар тогтоолоор баталсан “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлнэ.

4.2.23. Гамшгаас хамгаалах команд штабын иж бүрэн сургуулийг аймагт зохион байгуулж, гамшгийн бэлэн байдлыг хангана.

4.2.24. Жилд 2-3 суманд гамшгаас хамгаалах сургууль хийж, сумдын гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлнэ.

4.3. Батлан хамгаалах салбарын чиглэлээр:

4.3.1. Дайчилгааны бэлэн байдлыг дээшлүүлэн дайчилгааны бэлтгэл, нөөцийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлж, сургалт, дадлагыг сайжруулна.

4.3.2. Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс, Батлан хамгаалах тухай, Зэвсэгт хүчний тухай, Дайны байдлын тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиудыг нийт ард иргэдэд сурталчилан таниулж иргэдтэй эх оронч үзэл, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

4.3.3. Цэргийн штабыг орчин үеийн шаардлагад нийцсэн техник, тоног төхөөрөмжөөр хангаж, сургалт явуулах орчин нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3.4. Экологийн сүйрлээс сэрэмжлэн хамгаалах, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагаанд цэргийн дүйцүүлэх албаны оролцоог нэмэгдүүлнэ.

4.3.5. Аймагт барилгын цэргийн анги байгуулахад шаардагдах хөрөнгийг үе шаттайгаар шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

4.4. Гадаад харилцааны чиглэлээр:

4.4.1. Төрийн байгууллагуудын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, шинэ технологи, судалгаа, хүний нөөцийн сургалт, тоног төхөөрөмжийн шинэчлэлд хамтран ажиллаж сайн түншлэлийг бий болгоно.

4.4.2. Аймаг, сумын хөгжлийн бодлогыг эрчимжүүлэх зорилгоор зарим улс орны ижил статустай аймаг, хотуудтай хамтран ажиллах хамтын ажиллагааг өргөтгөнө.

4.4.3. Монгол дахь гадаадын Элчин сайдын яам болон Олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

4.4.4. Төрийн албан хаагчид, шаардлагатай салбарын мэргэжилтнүүдийг гадаад арга хэмжээнд оролцуулах, туршлага судлуулах, богино хугацаагаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

---o0o---